


# НЭЙШНЛ ЛАЙФ ДААТГАЛ КОМПАНИЙН ТАЙЛАН



2024

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

### 1 КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Туйлын зорилго, хэтийн зорилго, үнэт зүйлс  
Зорилго, бүтэц, бүрэлдэхүүн  
Онцлох контентууд  
Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа  
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт  
Дижитал хөгжүүлэлт  
Хөдөлмөрийн нөөц  
Нийгэмд түстай ажлууд

### 2 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн засаглалын кодексийн  
хэрэгжилтийн үнэлгээ  
Хувьцаа эзэмшигчдийн хурлын тайлан  
Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан  
Их хэмжээний болон сонирхлын  
зөрчилтэй хэлцлийн тайлан  
Гүйцэтгэх удирдлагын багийн үүргийн  
гүйцэтгэл, цалин урамшуулал  
Дотоод хяналтын тайлан

### 3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### 4 ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН, ДҮГНЭЛТ



**Г. МОНГОЛХҮҮ**

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ний  
Гүйцэтгэх захирал

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм харилцагч, түнш байгууллага, хувьцаа эзэмшигч Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

“Нэйшнл лайф даатгал” ХХК нь Монгол Улсад амьдралын даатгалын салбарын анхдагч компани болохын хувьд 2007 оноос хойш 17 дахь жилдээ тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байна. Үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш бид амь насны даатгал, хувийн эрүүл мэндийн даатгал, хуримтлалын болон тэтгэврийн даатгал, мөн хүнд өвчний эрсдэлийн даатгалын цогц шийдлүүдийг хэрэглэгчдэдээ хүргэхийн төлөө тууштай ажиллаж ирсэн билээ.

2024 он бол бидний хувьд шинэ түвшинд гарсан, стратегийн ач холбогдолтой олон үйл явдлаар дүүрэн жил байлаа. Харилцагчдадаа илүү ойр, хүртээмжтэй орчинд үйлчилгээ үзүүлэх зорилгоор төв оффисоо хотын А зэрэглэлийн бус рүү нүүлгэн шилжүүлж, хэрэглэгчийн үйлчилгээний стандарттаа шинэ шатанд гаргасан. Мөн ажлын цагийн шинэ зохион байгуулалтын тогтолцоо нэвтрүүлснээр ажилтнуудын амьдралын тэнцвэр, бүтээмжийг дэмжихэд чиглэсэн алхамыг хийлээ.

Түүнчлэн цахим шилжилтийн хүрээнд бид [www.mylife.mn](http://www.mylife.mn) платформоор эрүүл мэндийн даатгалтай харилцагчдын шууд төлбөр тооцооны системийг амжилттай нэвтрүүлж, үйлчилгээг илүү хурдан шуурхай үйлчилгээ үзүүлэх боломжийг бий болголоо.

Мөн 2024 онд хуулийн орчны томоохон шинэчлэл болох “Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам”-ын шинэчлэл батлагдаж, ипотекийн зээлдэгчид амь нас, эрүүл мэндийн даатгалыг зөвхөн урт хугацааны буюу амьдралын даатгалд хамрагдах шаардлагатай болсон нь урт хугацааны даатгалын хэрэглээг нэмэгдүүлэх, салбарын экосистемийг дэмжих чухал алхам боллоо.

Цаашид бид эрхэм зорилгоо тууштай хэрэгжүүлж, тасралтгүй хөгжил дэвшлийг эрхэмлэн, харилцагчид, түншүүд, хувьцаа эзэмшигчдийнхээ хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэхийг зорин ажиллах болно.

Бидэнд итгэж, хамтран ажиллаж ирсэн нийт харилцагчид, хамтрагч байгууллагууддаа чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Сэтгэл тайван амьдралыг хамтдаа бүтээ!

Хүндэтгэсэн:

Г.МОНГОЛХҮҮ


“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал

# 1 КОМПАНИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН





## ТҮЙЛЫН ЗОРИЛГО, ХЭТИЙН ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС



### ХЭТИЙН ЗОРИЛГЫН АРГА ЗАМ, ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ЗУРАГЛАЛ

АМЬДРАЛЫН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГААР ӨРХ БУРИЙН  
ЗОРИЛГОДОО ХҮРЭХ САНХҮҮГИЙН БАТАЛГААГ БИЙ БОЛГОЖ НИЙГЭМД  
ХҮРТЭЭМЖТЭЙ ҮНЭ ЦЭНИЙГ БҮТЭЭНЭ.

Амьдралын даатгалын үйл ажиллагаагаар өрх бурийн зорилгодоо хүрэх санхүүгийн баталгааг бий болгох

Хүн бурийн хэрэгзэнд тохицуулсан угсардаг хэвшиж буйх хүримтлал, хөрөнгө оруулалтын удирдлага болон эрдэлийн хамгаалалттай бүтээгдэхүүнийг төгөлдөрчүүлж, дикиталжуулах замаар зах эзэлд үйлчилгээг үзүүлэх

Системийн үйл ажиллагасаны үр дунгийн тогтвортой ёсслэний бий болгогд стратегийн болон төрөлжисэн тогтолцоонуудыг төгөлдөржүүлэх

Нийгэмд хүртээмжтэй үнэ цэнийг бүтээнэ.

Жил бур 10 тэрбум төгрөгийн дооршгүй нийц сан шинээр байгуудаг байх

ТУС БОНД индексийн түвшин тогтвортой хангадаг байх

Компанийн хувьцаа Монголын хөрөнгийн биржийн ТОП 20 индекс тогтолцоог багтдаг байх

СУДУУ төлөвлөсөн түвшинг тогтвортой хангадаг байх


Хадалмерийн нийцсийн тогтвортой хангадаг байх



## ЗОРИЛГО, БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

“Нэйшнл лайф даатгал” ХХК (цаашид “компани” гэх) 2024 онд “Компанийн засаглалыг бэхжүүлэх, ажлын байрны үнэ цэнийг нэмэгдүүлэх, даатгалын үйлчилгээг дижиталжуулах, мэргэшсэн оролцогчтой түвштай түншлэх замаар даатгалын хүртээмжийг нэмэгдүүлнэ” гэсэн зорилго тавьж хэрэгжүүлэн ажиллалаа.

Энэ онд компанийн бүтцэд өөрчлөлт ороогүй. Бүтцийг зургаар үзүүлбэл:





## ОНЦЛОХ КОНТЕНТУУД

1. Дэлхийн Монголчуудын радио MGL радиотой бүтэн жилийн гэрээ байгуулан радио сонсогч иргэддээ амьдралын даатгалын ач холбогдлыг таниулах, мэдлэг олгох контентуудыг бүтээн олон нийтэд хүргэв.



2. Battle X Zone шоу нэвтрүүлэгтэй 8 дугаарын турш хамтран ажиллаж цор ганц ялагч Нэйшнл Лайф даатгалын 450,000,000 сая төгрөгийн үнэлгээ бүхий олон улсын эрүүл мэндийн даатгалын эрхийн эзэн болов.



## **ОНЦЛОХ КОНТЕНТУУД**


3. Улаанбаатар Төмөр Зам Хувь Нийлүүлсэн Нийгэмлэг-ийн харьяа Ган зам пресс хэвлэлийн компанийтай хамтран ажиллах 1 жилийн гэрээ байгуулан амьдралын даатгалыг олон нийтэд таниулах цуврал нийтлэлүүдийг эрхлэн гаргав.



## ХЭРЭГЛЭГЧИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг хийх нь үйлчлүүлэгчид компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар ямар сэтгэгдэлтэй байгааг тодорхойлох хамгийн үр дүнтэй арга юм.

Бид ISO 9001:2015 дэлхийн стандартын дагуу хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг сар бүр тогтмол хийдэг. Энэхүү стандартын зорилго нь алдааг бууруулах, доголдлыг арилгах, хамгийн чухал нь урьдчилан сэргийлэхэд оршино. ISO 9001 Чанарын удирдлагын тогтолцоонд үйлчлүүлэгч үргэлж эхний байранд байдаг бөгөөд хэрэглэгчийн сэтгэл ханамжийг хянах зорилгоор хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийх хэрэгтэй байдаг.





## БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ


### Амь насны даатгалын шинэчлэл

Хураамжаа буцааж авах амь насны даатгалын бүтээгдэхүүнийг шинэчилэв. Энэхүү бүтээгдэхүүн нь гэрээний хугацаанд даатгалын тохиолдол бий болсон үед даатгуулагчид нөхөн төлбөр олгох, даатгалын тохиолдол үүсээгүй бол гэрээ эзэмшигчид нийт төлсөн хураамжийг буцаан олгодог амь насны даатгал юм. Энэ жилийн өөрчлөлтөөр даатгалын үнэлгээг нэмэгдүүлж, урамшуулал олгож эхлэх хугацааг 3 жил байсныг 2 жил болгон өөрчилж, цуцлах нөхцөлийг уян хатан болгох зэргээр даатгуулагчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн юм.



### Шинэ бүтээгдэхүүн

Ипотекийн зээлдэгчдэд зориулсан амь насны даатгалын шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв. Үг бүтээгдэхүүн нь зээлдэгч аливаа шалтгаанаар (өвчлөл, гэнэтийн осол зэрэг) амь насаа алдах эсвэл хөдөлмөрийн чадвараа алдах тохиолдолд тухайн зээлийн үлдэгдэл төлбөрийг нөхөн төлөх замаар зээлдэгчийн ар гэр болон санхүүгийн байгууллагыг эрсдэлээс хамгаалах зорилготой юм.





## БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

### Эрдэм боловсролын хуримтлалын даатгалын шинэчлэл


Хүүхдийн ирээдүйд хөрөнгө оруулалт хийхийг хүссэн эцэг эхчүүдийн хэрэгцээнд нийцүүлэн боловсролын хуримтлалын даатгалын бүтээгдэхүүнийг шинэчлэв. Энэ даатгал нь хүүхдийн ирээдүйн бүхий л зардалд зориулан мөнгөн хуримтлалыг илүү таатай нөхцөлөөр хуримтлуулах боломжийг олгох зорилготой юм.



## ДИЖИТАЛ ХӨГЖҮҮЛЭЛТ

### Шууд төлбөр тооцооны дижитал шийдэл нэвтрүүлэлт

Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн, санхүүгийн нөхцөл байдлаас үл хамааран цаг алдалгүй эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ авах боломжийг даатгуулагчид олгох зорилгоор "шууд төлбөр тооцооны" дижитал шийдлийг нэвтрүүлэв. Тус үйлчилгээг 2021 онд анх картын системээр хэрэгжүүлж эхэлсэн бол 2024 онд бүрэн дижитал хувилбарыг үйл ажиллагаандaa нэвтрүүлэв. Шууд төлбөр тооцооны дижитал шийдлийг манай компанийтай хамтын ажиллагаатай Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг магадлан итгэмжлэгдсэн томоохон хувийн эмнэлгүүдэд ашиглах боломжтой юм. Үүний үр дүнд хэрэглэгчид эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай, хялбар байдлаар ашиглах боломжтой болж байгаа юм.





## ДИЖИТАЛ ХӨГЖҮҮЛЭЛТ

### Odoo ERP V17

Компанийн дотоод үйл ажиллагааны үр ашиг, өгөгдлийн урсгалын уялдаа холбоог сайжруулах, шийдвэр гаргалтыг мэдээлэлд суурилсан, ил тод, хурдан шуурхай болгох зорилгоор "Odoo 17 enterprise" системийн шинэчлэлийн төслийг амжилттай хэрэгжүүлэв.

Энэхүү төслийг Энэтхэг улсын KSolves India Limited компанитай хамтран хэрэгжүүлсэн бөгөөд тус компани нь Odoo 17 enterprise-ийн албан ёсны Gold Partner статустай, олон улсын зах зээлд 10+ жилийн туршлагатай, бизнес процессын автоматжуулалт, системийн интеграцилал, дижитал трансформацийн чиглэлээр мэргэшсэн мэргэжлийн байгууллага юм.

Шинэчлэлийн хүрээнд Odoo ERP-ийн хамгийн сүүлийн хувилбар болох V17-г компанийн үндсэн үйл ажиллагаанд суурилуулан нэвтрүүлж, өгөгдлийн уялдаа холбоо, хяналт, боловсруулалтыг сайжруулав.

Шинэ систем нэвтэрснээр байгууллага дараах ахиц дэвшлийг гаргав:

- Өгөгдлийн давхардал, алдаа буурч, нэг эх сурвалжаас мэдээлэл авах боломжтой болов.
- Компанийн өдөр тутмын үйл ажиллагаа автоматжиж, хүний нөөц, санхүүгийн үйл ажиллагааны ачааллыг бууруулах нөхцөлийг бүрдүүлэв.
- Тайлан гаргах хугацаа хэмнэгдэж, удирдлагын түвшинд шуурхай шийдвэр гаргах нөхцөл бүрдэв.
- Системийн уян хатан байдал нэмэгдэж, ирээдүйд өргөтгөл, шинэ модулиуд нэвтрүүлэх, үлмаар дижитал шилжилтийн дараагийн шатанд шилжих суурь тавив.






## ДИЖИТАЛ ХӨГЖҮҮЛЭЛТ

### Google Cloud сервер

Компанийн мэдээллийн технологийн дэд бүтцийг сайжруулах, уян хатан, найдвартай, өндөр хамгаалалттай орчинд шилжүүлэх зорилгоор Google Cloud серверийн үйлчилгээнд бүрэн шилжилт хийв. Энэхүү шилжилтийн үр дүнд дараах ахиц дэвшил, давууд талууд бий болсон:

- Мэдээллийн аюулгүй байдлын өндөр түвшин.** Google Cloud нь олон улсын мэдээллийн аюулгүй байдлын ISO/IEC 27001, SOC 2, GDPR зэрэг стандартыг хангаж ажилладаг тул байгууллагын мэдээлэл дэлхийн жишигт нийцсэн орчинд хамгаалагдан хадгалагдах нөхцөл бүрдэв.
- Үйл ажиллагааны найдвартай байдал.** Серверийн тасралтгүй ажиллагаа, ачаалал тэнцвэржүүлэх автоматжуулсан шийдлүүдийн үр дүнд системийн гацалт, доголдол багасаж, хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж сайжрав.
- Хэмжээ, нөөцийн уян хатан байдал.** Үйл ажиллагааны өсөлт, хэрэглээний хэмжээтэй уялдуулан серверийн хүчин чадлыг бодитоор хянах, автоматаар тэлэх боломжтой болсон. Ингэснээр нөөцийг үр ашигтай удирдах, зардлыг оновчтой хуваарилах нөхцөл бүрдэв.
- Хөгжүүлэлтийн хурд.** Google Cloud-ийн хөгжүүлэлтийн дэд бүтэц (DevOps, CI/CD, API gateway гэх мэт) нь системийн шинэчлэл, нэмэлт хөгжүүлэлтийг хурдан хугацаанд нэвтрүүлэх боломжийг олгож, IT багийн бүтээмжийг мэдэгдэхүйц нэмэгдүүлэв.
- Автоматжуулсан Өгөгдлийн нөөцлөлт ба сэргээн босголт.** Cloud орчинд өгөгдлийг тогтмол нөөцлөх, шаардлагатай үед богино хугацаанд бүрэн сэргээх боломж бүрдсэн нь мэдээллийн аюулгүй байдлыг дахин нэг түвшинд баталгаажуулав.
- Олон улсын хамтын ажиллагаанд нийцсэн орчин.** Google Cloud серверийн ухаалаг архитектур нь олон улс дахь түнш байгууллагуудтай өгөгдөл солилцох, хамтран ажиллах, системийн уялдаа холбоог хангаход эерэг нөлөө үзүүлэв.

Эдгээр үр дүн нь компанийн үйл ажиллагааны хурдацтай өсөлт, дотоод нөөцийн оновчтой ашиглалтыг дэмжиж, харилцагчдад илүү найдвартай, чанартай үйлчилгээ үзүүлэх суурийг бүрдүүлж байгаа юм.





## ХӨДӨЛМӨРИЙН НӨӨЦ

### Цалин хөлс

Компани 2024 онд цалин, урамшуулал, хангамжийн журамд ажилтнуудын хариуцсан ажлын үр дүн, чанарт сууриссан цалингийн систем нэвтрүүлэхээр өөрчлөлтүүдийг оруулав. Ажилтан гэрээнд заасан үндсэн цалин дээрээ өдөр бүр үүргээ чанартай гүйцэтгэж, оноо цуглуулж нэмэгдэл цалин авдаг болов.

Энэ онд цалин хөлсний өрсөлдөх чадварын судалгаанд үндэслэн ажилтнуудын цалин хөлсний хэмжээг нэмэгдүүлэв. Цалин хөлсний хэмжээнд өөрчлөлт оруулснаар цалин хөлс, урамшууллын зардал 2023 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 2024 онд 32.5 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байв.

### Цагийн уян хатан зохицуулалт

Ажилтнуудын ажлын эхлэх, дуусах цагийг уян хатнаар зохицуулах нөхцөлийг журамд оруулж батлуулан хэрэгжүүлэв. Энэхүү өөрчлөлт нь ажилтнуудын ажил, амьдралын тэнцвэрийг хадгалах, сэтгэл ханамжийг дээшлүүлэх, улмаар бүтээмжийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлж байгаа юм.

### Сургалт хөгжил

2024 онд ажилтнуудын системийн мэдлэг олгох, шийдэл боловсруулах ур чадварыг хөгжүүлэх 5 төрлийн сургалтад давхардсан тоогоор нийт 32 ажилтан хамрагдав. Мэргэжлийн тусгай үр чадварыг хөгжүүлэх зорилгоор санхүү, нягтлан бодох бүртгэл, өгөгдөл мэдээлэл боловсруулах, сэтгэл хөдлөлөө удирдах чадварыг нэмэгдүүлэх 5 сургалтад нийт 10 ажилтнуудыг хамруулав. Мөн ажилтны ажлын байрны сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Менежментийн сэтгэл зүйч, зөвлөгч Ц.Энхжаргал багшаар "Стресс менежмент, эрч хүчний удирдлага" сургалтад нийт ажилтнуудаа хамруулав.





## ХӨДӨЛМӨРИЙН НӨӨЦ

### Нийтлэг арга хэмжээ

Ажилтнуудын ойр дотно байх хэрэгцээг хангах зорилгоор уламжлал болгон зохион байгуулагддаг хүүхдийн шинэ жил, хүүхдийн баяр, гэр бүлийн өдөр арга хэмжээнүүдийг зохион байгуулав. Компани үүсгэн байгуулагдсан үеэс үнэ цэн бүтээлцсэн ахмад ажилтнуудыгаа 10-р сард хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулав.

Энэ онд багийн ажлын үр дүнг нэмэгдүүлэх дэмжлэг үзүүлэх зорилгын хүрээнд багийн гишүүд өөрийгөө нээх, хамт олноо илүү сайн танин мэдэх, эерэг хандлага нэгдмэл уур амьсгалыг бий болгох, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн тоглоомын аргад суурилсан TEAM WORK, TEAM PLAY арга хэмжээг 6-р сард зохион байгуулав.



Компанийн борлуулалтыг нэмэгдүүлэх боломж, чиглэлүүдийг тодорхойлох зорилгоор 9 дүгээр сард "Компанийн борлуулалтыг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох" вакум хэлэлцүүлгийг зохион байгуулав. Хэлэлцүүлгийн хүрээнд компанийн ажилтнууд багуудад хуваагдан борлуулалтын сувгуудыг сайжруулах, шинэчлэх; компанийн брэндийг зах зээлд тогтвортой хоногшуулах арга замууд; контентын агуулга, төрөл, түгээх сувгийг шинэчлэх; өгөгдөл, мэдээллийн сан үүсгэх, ашиглах шийдлүүд; дотоод үйл ажиллагааны сайжруулалт зэрэг таван үндсэн сэдвийн хүрээнд илтгэл бэлтгэн танилцуулж, хамт олны дунд хэлэлцэв.

Даатгалын салбарын 90 жилийн ойг тохиолдуулан ажилтнуудад компанийн түүхэн замнал, бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээлэл өгөх, үр дүнтэй ажилласан ажилтнуудыг урамшуулах, ажилтнуудыг урт хугацаанд тогтвортой үр дүнтэй ажиллуулахад сэдэлжүүлэх зорилгоор даатгалын баярын өдөрлөгийг зохион байгуулав.





## НИЙГЭМД ТУСТАЙ АЖЛУУД

Авьяаслаг хүүхдэд 80 сая төгрөгийн "Эрдэм" боловсролын даатгал олгов.

2024 онд Монгол Улсад анх удаа зохион байгуулагдсан "The Voice Kids Mongolia" шоуны ялагчаар тодорсон авьяаслаг хүүхдэд 80 сая төгрөгийн боловсролын хуримтлалын даатгал олгов. Дэлхийн 47 улсад амжилттай хэрэгжсэн энэхүү шоу Монголд зохион байгуулагдсанаар хүүхэд багачуудын авьяас чадварыг нээн илрүүлсэн, үндэсний хэмжээний томоохон соёл, урлагийн арга хэмжээ болсон билээ.

Үг шоунд нийт 3000 гаруй хүүхэд бүртгүүлж, урьдчилсан шатны шалгаруулалтаар шилдэг 60 авьяаслаг хүүхэд телевизийн шууд шоугаар өрсөлдсөн юм. Тэдгээрээс хамгийн өндөр амжилт үзүүлж, ялагчаар тодорсон Э.Чингүүнд Нэйшнл Лайф Даатгалын "ЭРДЭМ" боловсролын хуримтлалын даатгалын 80 сая төгрөгийн эрх гардуулав.



Харилцагч компанийн хүнд өвчтэй ажилтанд санхүүгийн дэмжлэг үзүүлэв.

Манай компани нь нийгмийн хариуцлагыг эрхэмлэн ажилладаг байгууллагын хувьд харилцагч байгууллагын ажилтны хүнд нөхцөлд анхаарал хандуулж, Турк улсад яаралтай хагалгаанд орох шаардлагатай болсон нэгэн ажилтанд эмчилгээний зардалд зориулан тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэг үзүүлэв.



## НИЙГЭМД ТУСТАЙ АЖЛУУД

Үнэ төлбөргүй сургалт, хөгжлийн хөтөлбөр зохион байгуулав.

Бид 2024 оноос эхлэн улирал бүр хүний нөөц болон удирдах ажилтнуудад зориулсан сургалтыг ажиллах хүчийг тогтвортой ажиллах орчин нөөцийг бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор амжилттай зохион байгуулсаар байгаа билээ. Энэхүү сургалтад 300 гаруй хуулийн этгээд, хувь хүн хамрагдсан юм.



Нийтийн зориулалттай сандал байршуулав.

Нийгмийн хариуцлагын хүрээнд “Батцагаан” дуганы гадна талбайд нийтийн зориулалттай сандал байршуулах ажлыг хэрэгжүүлэв. Энэхүү санаачилга нь Улаанбаатар хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлж, иргэдийн амралт, тухлан суух орчныг сайжруулах зорилготой юм.



# 2 КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ





## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор "Компанийн засаглалын кодекс"-ийг шинэчлэн баталсан бөгөөд 2024 онд компанийн засаглалыг бэхжүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.

- Толгой компани болох Гүнд Инвестмент ХХК-ийн ТҮЗ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 24/02/01 тоот тогтоолоор баталсан "Гүнд инвестмент холдингийн хөрөнгө оруулалттай компаниудын төлөөлөн удирдах зөвлөл болон манлайллын багийн бүтэц, тэдгээрийн цалин, урамшууллын бодлогын баримт бичиг"-ийг мөрдөж ажилласан.
- Гүнд Инвестмент холдингийн хэмжээнд охин, хараат компаниудын ТҮЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүргийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын үр дүнтэй, оновчтой бүтцийг бий болгох зорилгоор Гүнд Инвестмент ХХК-ийн ТҮЗ-ийн дэргэдэх байнгын үйл ажиллагаатай "Хөрөнгө оруулалтын хороо", "Хяналт, оношилгооны хороо", "Засаглалын хороо"-г байгуулахаар шийдвэрлэв.
- ТҮЗ-ийн гишүүд, ТҮЗ-ийн Нарийн бичгийн жилийн тайлан, ТҮЗ-ийн үйл ажиллагааны тайлан, жилийн сургалтын төлөвлөгөөг боловсруулж баталгаажуулж эхэлсэн;
- Компанийн албан ёсны сайт болох nlic.mn цахим хуудасны "Хөрөнгө оруулагчид" (<https://nlic.mn/investor>) цэсийн "Компанийн засаглал" хэсэгт дараах шийдлүүдийг байршуулав.
  - Сонирхлын зөрчилтэй хэлцлийг шийдвэрлэх журам
  - Мэдээллийн урсгалын журам
  - ТҮЗ-ийн хурлын журам
  - ХЭХ-ын журам

Компани нь зохицуулалттай этгээд болохын хувьд жил бүр өөрийн үнэлгээг хийж Санхүүгийн зохицуулах хороогоор хянан баталгаажуулж ажиллаж байна. Баталгаажуулалтын мэдээллийг бүлгээр харуулбал,

Компанийн үнэлгээ 2023 онтой харьцуулахад буурсанд СЗХ-оос үнэлгээний аргачлалаа өөрчилж хэрэгжилтийг хэмжих үзүүлэлтийг илүү нарийвчлан шаарддаг болсон нь нөлөөлсөн.

Кодексийн шаардлага /бүлгээр/	Авбал зохих ондоо	2022 оны үнэлгээ	2023 оны үнэлгээ	2024 оны үнэлгээ
Нэгдүгээр зарчим. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт.	12	5	10	8
Хоёрдугаар зарчим. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	4	7	6
Гуравдугаар зарчим. Тайлантал, мэдээллийн ил тод байдал	6	3	4	4
Дөрөвдүгээр зарчим. Аудит, хяналтын тогтолцоо	6	5	6	6
Тавдугаар зарчим. Эрсдэлийн удирдлага	8	4	8	8
Зургаадугаар зарчим. Эрх бүхий албан тушаалтын цалин урамшуулал	6	5	6	6
Долоодугаар зарчим. Оролцогч талуудын эрх ашиг	8	7	8	7
Наймдугаар зарчим. Компанийн соёл	6	5	4	5
Есдүгээр зарчим. Хувьцаа эзэмшигчийн эрх	10	9	10	8
Нийт	72	47	63	58
<b>Үнэлгээний хувь</b>	<b>100%</b>	<b>65.20%</b>	<b>87.50%</b>	<b>80.56%</b>



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ


### Хувьцаа эзэмшигчдийн хурлын тайлан

"Нэйшнл лайф даатгал" ХХК-ийн энгийн хувьцааг "Эф Эс Си Θү" ХХК нь 100 хувь дангаар эзэмшиж байх хугацаанд буюу 2024 онд 2 удаа хуралдаж 10 асуудлыг асуудлыг хэлэлцэж 13 шийдвэр гаргаж баталгаажуулав.


2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТҮЗ-ийн дүгнэлтийг батлах, компанийн дүрмийг шинэчлэн батлах, компани үүсгэн байгуулагдсанаас хойших хугацаанд үнэ цэн бүтээлцсэн иргэдэд хувьцаа эзэмшүүлэх, ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх асуудлыг шийдвэрлэв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн үнэ цэн бүтээлцсэн иргэдэд хувьцаа эзэмшүүлэх шийдвэрийн дагуу хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос авч, 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр улсын бүртгэлд бүртгүүлж баталгаажуулав.

### Хувьцаа эзэмшигчийн бүтэц



"Эф Эс Си Θү" ХХК



Үнэ цэн бүтээлцсэн иргэд /ажилтнууд/

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн нэгдлийн оролцогч 5 компанийтай байгуулах 11 гэрээний гол нөхцөлийг тогтоож хэлцэл хийх зөвшөөрөл олгож шийдвэрлэв.



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### ТҮЗ-ийн үйл ажиллагааны тайлан

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын журамд заасны дагуу 2024 онд улирал бүрийн ээлжит хурлаар 24 асуудлыг, 4 удаагийн ээлжит бус хурлаар асуудлыг 14 асуудлыг хэлэлцэж, нийт 8 удаа 59 цаг хуралдав.

Хурлын хэлбэр	Хуралдсан огноо	Хурлын ирц	Нийт цаг
Ээлжит	2024/01/05, 2024/01/29, 2024/02/01	2024 оны 01 дүгээр сарын 15, 01 дүгээр сарын 29, 02 дугаар сарын 01-ний өдрийн хурлын ирц 100%	8
Ээлжит бус	2024/03/04, 2024/03/15	2024 оны 03 дугаар сарын 04, 03 дугаар сарын 15-ны өдрийн хурлын ирц 100%	8
Ээлжит бус	2024/04/12	2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн хурлын ирц 100%	7
Ээлжит	2024/04/30	2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын ирц 80%	8
Ээлжит бус	2024/05/29	2024 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн хурлын ирц 100%	3
Ээлжит	2024/08/01	2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн хурлын ирц 100%	8
Ээлжит	2024/10/16	2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хурлын ирц 100%	8
Ээлжит бус	2024/11/27, 2024/12/05, 2024/12/13, 2024/12/20	2024 оны 11 дүгээр сарын 27, 12 дугаар сарын 02, 12 дугаар сарын 13, 12 дугаар сарын 20-ны өдрийн хурлын ирц 100%	13



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ


### ТҮЗ-ийн үйл ажиллагааны тайлан

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2024 онд хэлэлцсэн 38 асуудлаас 25 асуудлыг баталж 31 тогтоол гаргаж, 8 асуудлаар дүгнэлт, санал гаргав. Харин 10 асуудлыг дахин хэлэлцүүлэхээр буцаасан байна.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь өмнөх онуудтай харьцуулахад хэлэлцэх асуудлын тоо болон буцаасан асуудлын тоо буурсан төлөвтэй байна. ТҮЗ нь жил бүр дунджаар 20 гаруй тооны системийн хэвийн үйл ажиллагааг хангах стратегийн суурь болон төрөлжсөн тогтолцоог бүрдүүлэх бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны болон бүтээгдэхүүний журмын шийдлийг хэлэлцсэн байх бөгөөд 2024 онд хэлэлцсэн нийт асуудлын 44.7 хувийг эзэлж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцсэн шийдлийн тоо

■ Хэлэлцсэн асуудлын тоо ■ Журам, БББ-ын тоо



Компанийн ТҮЗ-ийн гишүүний үргэлжилсэн сургалтын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны Сургалтын журмын 2.3.7 болон 2.4.2-т заасны дагуу Комплаенс, МҮТСТ чиглэлээр удирдах ажилтны мэргэшүүлэх сургалтад хамрагдаж, сертификат авсан байх үүргийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТҮЗ-ийн дарга Ж.Бат-Ирээдүй, ТҮЗ-ийн гишүүн Р.Ганчимэг, А.Анар, Г.Монголхүү, Б.Баярцэнгэл нар сургалтад хамрагдав.



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл

Компани нь 2024 онд Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан их хэмжээний хэлцэл хийгээгүй байна.

Компани нь 2024 онд Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1-д заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд хамаарах 5 хуулийн этгээдтэй Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлаас зөвшөөрөл авсны үндсэн дээр нийт 11 хэлцэл хийв.

Харилцан хамааралтай компаниуд болох "Синержи Фанд солюшн" ХХК, "Эн Ви Си ББСБ" ХХК-тай Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, Судалгааны ажил гүйцэтгүүлэх гэрээ, "Гүнд инвестмент" ХХК-тай Санхүүгийн түрээсийн гэрээ, Мэдлэг солилцох төвийг ашиглах гэрээ, Менежментийн гэрээ, "Рийч Поинт" ХХК-тай оффисын үйлчилгээний гэрээ, "Сократус Студио" ХХК-тай Үйлчилгээ үзүүлэх гэрээнүүдийг хийсэн байна. Нийт гэрээний үнийн дүн 2.3 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаагаас Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ 2,0 тэрбумыг эзэлж байна.

"Нэйшнл Лайф Даатгал" ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 11 сарын 18-ны өдрийн 02/23-41 тоот тогтоолын хавсралтаар баталсан "Сонирхлын зөрчилтэй хэлцлийг шийдвэрлэх журам"-ын 2.4-д хууль тогтоомж болон хэлцэл хийгдэхээс өмнөх хугацаанд сонирхлын зөрчилтэй этгээд эсэхээс үл хамааран хэлцлийн гол нөхцөлийг ТУЗ/ХЭХ-ээс урьдчилан тогтоосон тохиолдолд зөвшөөрөл авах шаардлагагүй хэлцлүүдийг тусгав.

Иймд өмнөх хэсэгт дурдсан хэлэлцүүлэгд "Сонирхлын зөрчилтэй хэлцлийг шийдвэрлэх журам"-ын 2.4-д заасан зөвшөөрөл авах шаардлагагүй хэлцлүүдийн дүнг тусгаагүй болно. Үүнд:

- Компанийн тухай хуулийн 92.5-д заасан компанийд зээл олгох гэрээ;
- Компанийн тухай хуулийн 92.6-д заасан тухайн этгээдийн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдээр тооцогдохоос өмнө компанийн өдөр тутмын аж ахуйн үйл ажиллагааны явцад байгуулагдсан хэлцэл;
- ТУЗ-өөс баталсан стандарт нөхцөл бүхий даатгалын гэрээ, түүнтэй холбогдох бусад гэрээ;
- ТУЗ, ХЭХ-аас баталсан шийдлүүдэд заасны дагуу байгуулж буй гэрээ, хэлцэл;



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### Гүйцэтгэх удирдлагын баг /манлайллын баг/-ийн үүргийн гүйцэтгэл, цалин, урамшуулал

Гүйцэтгэх захирал, газрын захирлуудын үүрэг, хариуцлага, цалин хөлсний асуудлыг толгой компани болох “Гүнд Инвестмент” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан “Манлайллын багийг сонгон шалгаруулах, ажиллуулах, ажлын үр дүнг үнэлэх журам”-аар зохицуулж байна.

#### Манлайллын багийн гишүүдийн үүрэг

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-д зааснаар гүйцэтгэх захирал “Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах” үүрэгтэй. Холдингийн хувьд дээр дурдсан журмын дагуу газар нэгжийн хариуцсан менежерүүд компанийн зорилгыг тогтвортой хэрэгжүүлэхэд системийг үүсгэх, чиглүүлэх, төгөлдөржүүлэх үндсэн үүрэгтэй. Мөн зорилгыг хэрэгжүүлэх үүргүүдийн гүйцэтгэлийг дэмжсэн, зорилгын хэрэгжилтийн үр дүнд ээрэг нөлөөтэй уялдуулах үүргүүдтэй юм. Манлайллын багийн гишүүдийн үүргийн гүйцэтгэлийг холбогдох журмын дагуу 7 хоног, сар, улирлаар хэмжиж ажиллав.

#### Манлайллын багийн гишүүдийн цалин хөлсний бүтэц

Манлайллын багийн гишүүдийн цалин хөлс нь үндсэн цалин, үүргээ чанартай гүйцэтгэсний нэмэгдэл, үр дүнгийн нэмэгдэл гэсэн хэсгээс бүрддэг. Мөн дээр дурдсан журамд заасан шалгуурыг хангасан нөхцөлд зэргийн, дэвийн, манлайллын багийн үр дүнгийн гэсэн урамшууллууд олгогдож байгаа юм.

№ Цалин хөлсний нэр	Цалин, урамшуулал олгох шалгуур
1 Манлайллын багийн гишүүдийн сарын цалин	<ol style="list-style-type: none"><li>Гүйцэтгэх захирлын ажилласан цаг</li><li>Гүйцэтгэх захирлын үүргийн гүйцэтгэл</li></ol>
2 Манлайллын багийн гишүүдийн үлмрлын үр дүнгийн нэмэгдэл	<ol style="list-style-type: none"><li>Компанийн системийн үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлт буюу СҮДҮ-ийн гүйцэтгэл</li><li>Газар нэгжийн үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлт буюу газрын СҮДҮ-ийн гүйцэтгэл</li></ol>
3 Манлайллын багийн гишүүдийн жилийн үр дүнгийн урамшуулал	<ol style="list-style-type: none"><li>Компани, байгууллагын эрүүл мэндийн төлөв байдлын ТҮС индексийн жилийн зорилтот түвшиний гүйцэтгэл</li><li>Компанийн ажилтнуудын хувийн гүйцэтгэлийн индексийн дундаж 170-аас доошгүйгээр хангах</li><li>Хөдөлмөрийн нөөцийн төлөвшилтийн индекс / энэ үзүүлэлтийг ажилтнуудын үр чадвар хөгжүүлэлтийн индекс, бүтээлийн индекс, ажилтнуудын үүргийн гүйцэтгэлийн тогтвортжилтын индекс, хөдөлмөрийн нөөцийн тогтвортжилтын индекс гэсэн 4 үзүүлэлтээр хэмждэг/-ийн зорилтот түвшиний гүйцэтгэл</li></ol>
4 Манлайллын багийн гишүүдийн дэв	<ol style="list-style-type: none"><li>Компанийн ажилтнуудын ХГИ-ийн дундаж 187-аас дээу байх</li><li>2 жил дараалан МҮДҮ-ийн гүйцэтгэл 95%-с дээш байх</li></ol>
5 Манлайллын багийн гишүүдийн зэрэг	<ol style="list-style-type: none"><li>2 улирал дараалан компани / байгууллагын СҮДҮ-ийн гүйцэтгэл цэвэр дүнгээр 90%-с дээш байх</li><li>2 улирал дараалан МҮДҮ-ийн гүйцэтгэл 95%-с дээш байх</li></ol>



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ


### Дотоод хяналт

Компанийн дотоод хяналтыг Оношилгоо, мониторингийн журам, Мэдээллийн урсгалын журам, Санхүүгийн үйл ажиллагааны журмын дагуу компанийн дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

### Системийн мониторинг

"Нэйшнл Лайф Даатгал" ХХК нь 2015 оноос үйл ажиллагаандaa системийн онолд сууринсан "байгууллага зорилгоо тогтвортой хэрэгжүүлэх чадвартай тогтолцоог бий болгодог" менежментийн ТУС загварыг нэвтрүүлж байгаа билээ. Энэхүү загвар нь компанийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын үүргийг уялдуулсан шийдлүүдээ гарган, хэрэгжилтэд нь мониторинг, оношилгоо хийж, тэдгээрт үндэслэн сайжруулалтыг тогтмол төлөвлөж хэрэгжүүлэх замаар дотоод хяналт тасралтгүй хэрэгжүүлдэг загвар юм.

Энэхүү загварыг хэрэгжүүлэх эхний үе шатанд 5 суурь тогтолцоог бүрдүүлдэг шийдлүүдээ гарган үйл ажиллагааны 5 функцийн хүрээнд хэрэгжүүлдэг ба үүнийг зурагт үзүүлбэл:



P – Plan – Төлөвлөх, D – Do – Хийх, C – Check – Хэмжих, A – Adjust - Сайжруулах,  
Alignment - Уялдуулах

Өнгөрсөн хугацаанд эдгээр суурь тогтолцоог бүрдүүлэх журмуудаа батлуулан хэрэгжүүлж, ТУСС ХХК-аар 2024 онд хэмжүүлэхэд 93,8 хувиар ASA-1 түвшинг хангасан үзүүлэлттэй гарав.

Энэ загварыг хэрэгжүүлэх дараагийн үе шат бол Хэрэглэгчийн менежментийн; Ур чадварын менежментийн; Эрсдэлийн удирдлагын, Санхүүгийн менежментийн, Ханган нийлүүлэлтийн менежментийн гэсэн 5 дэд тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байдаг. Эдгээр дэд тогтолцооны хэв шинжийн бүрдүүлэлтийг ТУСС ХХК-аар 2024 онд хэмжүүлэхэд эрсдэлийн удирдлагын дэд тогтолцооны үнэлгээ 80,2 хувьтай хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Бусад дэд тогтолцооны хэв шинжийг бүрдүүлэх алхмуудыг үргэлжлүүлэн хийж байна.



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлийн мониторинг

Компанийн дунд хугацааны зорилгыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2027 он хүртэл гарган үүнд нийцүүлэн богино хугацааны буюу жилийн төлөвлөгөөг гарган ажиллаж байна. 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хүснэгтээр үзүүлбэл:

№	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Нийт ажлын тоо	2590	2510
1.1	ЖЖКУАТ-д туссан төлөвлөгөөт ажил	2541	2461
1.2	ТГА ажлын тоо	49	49
2	Зохицуулалт хийсэн ажлын тоо	0	80
2.1	Зохицуулалт хийж хугацааг хойшлуулсан	0	74
2.2	Зохицуулалт хийж YAT-өөс хасагдсан ажлын тоо	0	6

### Системийн үйл ажиллагааны үр дүн /СҮДҮ/-гийн мониторинг

Системийн үйл ажиллагааны үр дүнг оролцогч талуудын ашиг сонирхлыг тусгасан 6 үзүүлэлтээр хэмждэг бөгөөд төлөвлөлтийн журмын дагуу жил бүр зорилтот түвшинг төлөөлөн удирдах зөвлөл баталж, гүйцэтгэлийг тайлагнадаг бөгөөд 2024 онд СҮДҮ-ийн гүйцэтгэл 76.3 хувийн биелэлттэй байв.

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны төлөвлөгөө	2024 оны гүйцэтгэл	Биелэлт
1	Хэрэглэгчдэд бүтээсэн үнэ цэнэ	мян.төг	6,391,929.961	3,867,517.84	60.5%
2	Хөдөлмөрийн бүтээмж	мян.төг/хүн цаг	92.949	67.7421	72.9%
3	Ажилтанд бүтээсэн үнэ цэнэ	мян.төг/цаг	19.174	20.3787	72.9%
4	Зардлын бүтээмж	төг/төг	1.123	0.9240	82.3%
5	Хөрөнгийн бүтээмж-Хур/О	төг/төг	0.426	0.3299	77.4%
6	Хөрөнгийн бүтээмж-ХОО	төг/төг	0.108	0.1175	108.5%
	Дундаж				76.3%




## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### Оношилгооны тайлан

Компанийн үйл ажиллагаанд тулгарч буй асуудал үүсгэж байгаа шалтгааныг танин мэдсэний үндсэн дээр шалтгааныг арилгах ажлуудыг тодорхойлж төлөвлөн хэрэгжүүлэх зорилгоор оношилгоог тогтмол хийж байна.

Компанийн Оношилгооны мониторингийн зөвлөлөөр 2024 онд 293 оношилгоог хэлэлцүүлсэн бөгөөд тус оношилгоонос 79 системийн шийдлийн дутмаг байдал буюу догоолдол, 40 ур чадварын дутагдлыг илрүүлж цаашид хийх ажлаа тодорхойлж хэрэгжүүлэв.



### Санхүүгийн дотоод хяналтын мониторинг

Компанийн санхүүгийн дотоод хяналтын чиг үүргийг “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн толгой компани “Гүнд Инвестмент” ХХК хэрэгжүүлж байна. Үүнд:

Санхүүгийн дотоод аудитын хүрээнд мөнгөн гүйлгээ, авлага өглөгийн наслжилтын тайлан болон барагдуулалтын мэдээлэлд хяналт тавих, санхүүгийн тайлан болон татварын тайлангийн мэдээлэл үнэн зөв эсэхэд хяналт тавих, санхүүгийн үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дотоод дүрэм, журамд нийцсэн эсэхийг хянан баталгаажуулж алдаа зөрчлийг илрүүлж компанийд мэдэгдэн залруулах арга хэмжээг хэрэгжүүлэхийг даалгадаг. Мэдээллийн урсгалын журам, санхүүгийн үйл ажиллагааны журмын хүрээнд 20 гаруй мэдээллийг тогтмол давтамжтай хүргүүлж байгаа юм.

Энэ хүрээнд толгой компаниас компанийн санхүүгийн үйл ажиллагаанд ноцтой зөрчил гарсан дүгнэлт ирүүлээгүй. Хэвийн бус буюу аливаа алдаа, зөрчил илрээгүй болно.



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

### Дүрэм, журам, шийдвэрийн мониторинг

Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирлаас гаргасан шийдвэр нь хууль тогтоомж, дотоод дүрэм, журамд нийцсэн эсэхийг хянан баталгаажуулах, суурь тогтолцооны дүрэм болон журмын хэрэгжилтэд толгой компанийн дотоод хяналт хариуцсан хуульч нь мониторинг хийж гүйцэтгэв.

Nº	Журмын нэр	Журмын зорилгын хэрэгжилтийн түвшин /хувиар/
1	Оношилгоо, мониторингийн журам	81%
2	Төлөвлөлтийн журам	86%
3	Цалин хангамж урамшууллын журам	100%
4	Хөдөлмөрийн харилцааны журам	83%
5	Мэдээллийн үргалын журам	99%
	Нэгдсэн дүн	89.80%

"Нэйшнл Лайф Даатгал" ХХК-ийн удирдлагаас 2024 онд гарсан 150 шийдвэр нь гаргаснаас 149 шийдвэр нь хууль тогтоомж, компанийн дүрэм, журамд нийцсэн, 1 шийдвэр нь техникийн алдаа гаргасны улмаас зөрчилтэй гэж дүгнэлт ирүүлсэн байна.

Nº	Шийдвэр гаргах үүрэг бүхий этгээд	Зөрчилгүй шийдвэрийн тоо	Зөрчилтэй шийдвэрийн тоо	Нийт шийдвэрийн тоо
1	Хувьцаа эзэмшигчдийн хурал	13	0	13
2	Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал	31	0	31
3	Гүйцэтгэх захирал	106	1	107
	Нийт	105	1	149

### Байгаль орчин, нийгэмд үзүүлсэн нөлөөллийн мониторинг

Манай компани Оношилгоо, мониторингийн журмын дагуу Байгаль орчин, нийгэмд үзүүлсэн нөлөөллийн мониторингийн дүгнэлтийг ТУС Солюшн компаниас баталсан аргачлалын дагуу 2024 онд гаргаж Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлдэг засаглалын тайландаа хавсарган хүргүүлсэн. Энэ хүү аргачлалын дагуу Нийтлэг нөөцийн хэрэглээний бүтээмжийн индекс, Бохирдуулалтын бүтээмжийн индекс, Нийгэмд шууд нөлөөллийн индекс, Нийгэмд үзүүлж буй арвижсан нөлөөллийн индекс, Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн индекс, Нийгэмд үзүүлэх нөлөөллийн индексээр хэмжиж дүгнэдэг. 2024 оны БОНЗ-ийн мониторингийн дүгнэлт:

- Нийтлэг нөөц болон бохирдуулалтын индекс хэвийн түвшинд байгаа тул компанийн үйл ажиллагаа байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байна.
- "Нийгэмд шууд нөлөөллийн индекс", "Нийгэмд үзүүлж буй арвижсан нөлөөллийн индекс"-ийн дүн 1-ээс бага гарагад борлуулалтын орлого төлөвлөсөн түвшинд хүрээгүй нь төлөвлөгөөт ажлын байранд ажилтан авах хэрэгцээ шаардлага үүсээгүй болох нь нөлөөлсөн.
- Индексийн зөрүү бага байгаа тул компани нь иргэдийг ажлын байраар хангаж, дотоодын компаниудаас худалдан авалт хийж, улсад татвар төлж нийгэм, эдийн засагт 2024 онд үнэ цэн бүтээсэн дүгнэв.

# **3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**



## САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### Даатгалын хураамжийн орлогын тайлан

2023 оноос хураамжийн орлогыг акруал сууриар бүртгэж эхэлсэн нь хураамжийн өсөлтийн үзүүлэлт нөлөөлсөн байна. Тодруулбал, 2024 онд тайланда хураамжийн 3.45 тэрбум төгрөгөөр тайлагнагдсан хэдий ч 2024 онд хийсэн гэрээний дагуу орох 688 сая төгрөгийн урьдчилж орсон хураамжийн орлого хэлбэрээр бүртгэгдсэн байна.

Nº	Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он
	Нийт хураамжийн орлого	2,565,360,705	3,000,457,025	3,455,991,205

2022 онд "Министер тауэр"-т оффисын барилгын худалдан авах захиалга өгснөөр 2023-2024 онуудад хөрөнгө оруулалтын багцын хэмжээ буурсан боловч 2024 онд "Синержи фанд солюшн" хөрөнгө оруулалтын менежментийн компанийтай гэрээ байгуулж хөрөнгөө удирдуулснаар 2024 оны хөрөнгө оруулалтын өгөөжийн түвшинг 21%-д хүргэсэн. Энэ нь хөрөнгө оруулалтын орлогын дүн өмнөх жилүүдтэй харьцуулахад өсөхөд нөлөөлсөн байна.

Nº	Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он
1	Хөрөнгө оруулалтын багц	6,745.34	7,181.3	6,838.9
2	Хөрөнгө оруулалтын орлого	1,030.2	1,199.0	1,203.5
3	Багцын өгөөж	14.4%	17.6%	21.0%

### Цалин хөлс, нөөц сан

Nº	Үзүүлэлт	2022 он	2023 он	2024 он
1	Цалин хөлс	788,162,360	756,512,378	1,002,330,837
2	Нөөц сан	2,874,693,555	3,022,879,730	4,054,471,121

- 2024 оны ажилтнуудын цалинг 30 орчим хувиар нэмэгдүүлснээр цалин хөлс урамшууллын зардлын хэмжээ 2024 онд өссөн үзүүлэлтэй гарсан байна.
- Нийт даатгалын нөөц сангийн 87 хувийг тэтгэвэр, хуримтлалын даатгалын нөөц сан эзэлж байна.



## САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### Орлого үр дүнгийн тайлан

2023 оноос хураамжийн орлогыг акруал сууриар бүртгэж эхэлсэн нь хураамжийн өсөлтийн үзүүлэлт нөлөөлсөн байна. Тодруулбал, 2024 онд тайланд хураамжийн 3.45 тэрбум төгрөгөөр тайлагнагдсан хэдий ч 2024 онд хийсэн гэрээний дагуу орох 688 сая төгрөгийн урьдчилж орсон хураамжийн орлого хэлбэрээр бүртгэгдсэн байна.

Nº	Санхүүгийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	226,130,985.74	186,751,550.26
1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	67,364,174.55	89,216,687.03
1.2	Даатгалын авлагын дүн	108,222,023.82	442,378,233.33
1.3	Бусад санхүүгийн хөрөнгийн дүн	242,392,002.61	284,980,785.88
1.5	Хөрөнгө оруулалтын дүн	7,453,468,894.28	6,986,863,778.66
1.6	Үндсэн хөрөнгө /Цэвэр/	1,772,372,149.89	2,684,852,143.20
1.7	Биет бус хөрөнгө /Цэвэр/	38,500,000.00	5,500,000.00
1.8	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,908,450,230.89	10,680,543,178.36
2	ӨР ТӨЛБӨР, ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Даатгалын өглөгийн дүн	7,674,763.76	16,340,469.27
2.2	Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн	16,620,447.33	226,565,299.64
2.3	Бусад санхүүгийн бус өр төлбөрийн дүн	660,780,897.16	772,013,493.05
2.4	Нөөц сангийн дүн	3,022,879,730.53	4,054,471,121.70
2.5	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	3,707,955,838.78	5,069,390,383.66
2.6	Эзэмшигчдийн өмч	6,000,750,000.00	6,000,750,000.00
2.7	Хуримтлагдсан ашиг, алдагдал	199,744,392.11	/389,597,205.30/
2.8	ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	6,200,494,392.11	5,611,152,794.70
2.9	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН БА ЭЗДИЙН ӨМЧИЙН	9,908,450,230.89	10,680,543,178.36

ДААТГАГЧИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ТУВШИН-2024.12.31					
X(%) Y(%)	X < (minX-20)	(minX-20) ≤ X < (minX-10)	(minX-10) ≤ X < minX	X ≥ minX	
0≤Y<10					
10≤Y<20				Төлбөрийн чадвар хангалттай	→ → → → → Чанар → → → → →
20≤Y<40					
Y≥40					
	→ → → → → Тоо хэмжээ → → → →				
	Х – Хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаа Ү – Зөвшөөрөгдхгүй хөрөнгийн харьцаа minX – Хөрөнгийн хүрэлцээт байдлын байвал зохих доод харьцаа <b>ДААТГАГЧИЙН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ШАЛГУУР</b> <b>ҮЗҮҮЛЭЛТ,</b> <b>ТУҮНД ХИНАЛГТ ТАВИХ ЖУРАМ</b>				
	2.19.2 Хоёрдугаар түвшин буюу даатгагчийн төлбөрийн чадвар хангалттай; 4.1.2 Даатгагчийн төлбөрийн чадвар хоёрдугаар түвшиний хурсэн тохиолдолд төлбөрийн чадварын түвшингийн сайжруулах төлөвлөгөө болон шаардлагатай гэж үзсэн бусад баримт материалыг Хороонд ирүүлж хангуулахыг шаардаа бөгөөд шаардлагатай тохиолдолд газар дээрх хинатал шалгалтыг хэрэгжүүлж;				

# **4** ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН, ДҮГНЭЛТ



## ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН, ДҮГНЭЛТ

2024 оны санхүүгийн тайлангийн хараат бус аудитыг Грант Торnton аudit ХХК-аар гүйцэтгүүлсэн бөгөөд тухайн аудитаас "Санхүүгийн байдал болон уг өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ бүх материаллаг зүйлсийн хувьд СТОУС-д нийцүүлэн Сангийн сайдын баталсан дүрэм журмын дагуу үнэн зөв бодитой илэрхийлэгдсэн байна" гэж дүгнэгдсэн болно.



Grant Thornton

"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК  
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний  
дэлхийн сүлжээний бие даасан фирм

Далай тауэр, 9 давхар  
ЮНЭСКО-ийн гудамж-31  
Сүхбаатар дүүрэг,  
1-р хороо, Улаанбаатар  
14230, Монгол Улс  
Т + 976 70 110744  
+ 976 70 110799

## Хараат бус аудиторын дүгнэлт

"Нэйшил лайф даатгал" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

### Дүгнэлт

Бид "Нэйшил лайф даатгал" ХХК (цаашид "компани" гэх) -ийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангуудад (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлгээ. Үнд:

- Санхүүгийн байдлын тайлан,
- Орлогын дэлгэрэнгүй тайлан,
- Өмчийн өөрчилгэлийн тайлан,
- Мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- Материаллаг нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл болон бусад тайлбар тодруулгууд

Бидний дүгнэлтээр, "Нэйшил лайф даатгал" ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу илэрхийлгэсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-үүдүн дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүргээ хариуцлагaa энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүргээ хариуцлагaa гэсэн хэсэгт харуулав.

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн ёс зүйн үүргээ хариуцлагaa бүрэн билэлүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход ханглалттай, зохицтой гэж итгэж байна.

### Тасралтгүй зарчимтай холбоотой материаллаг тодорхойгүй байдал

"Нэйшил лайф даатгал" ХХК нь 2023 онд 216,361 мянган төгрөг, 2024 онд 589,341 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж, дараалсан 2 жил алдагдал хүлээгээд байна. Энэ нь компанийн тасралтгүй зарчмаар үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадавхад эргэлээ терүүлэхийц материаллаг тодорхойгүй байдал оршин байгааг илтгэж байна. Бид санхүүгийн тайлангийн Тодруулга 2.2-д энэ асуудлыг онцолж, тодруулсан.

## Аудитын аргачлалын хураангуй

Аудитын гол асуудлууд	<ul style="list-style-type: none"> <li>Компани нь даатгалын нөөц санг актуальн арга техник ашиглан тооцоолдог ба даатгалын бүтээгдэхүүний онцлогоос хамааран хураамжийн орлогыг аккруэл болон мөнгөн сууриар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.</li> </ul>
Материаллаг байдал	<ul style="list-style-type: none"> <li>Санхүүгийн тайлангийн аудитад ашигласан нийт материаллаг байдал нь 63,955.1 мянган төгрөг ба материаллаг байдлыг сонгохдоо нийт орлогын 2% болон цэвэр хөрөнгийн 1%-иар тооцсон дүнгүүдийн дунджаар тогтоосон.</li> <li>Даатгалын компанийн санхүүгийн баталгаатай байдлыг илэрхийлэх үзүүлэлт учраас цэвэр хөрөнгийг суурь үзүүлэлтээр сонгосон. Санхүүгийн тайланд нөлөөлөх хэмжээг харгалзан үзэж 1 хувиар тооцсон.</li> <li>Компанийн үндсэн үйл ажиллагааны гол үзүүлэлт болох нийт орлогыг материаллагын суурь үзүүлэлтээр сонгож, санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг хэмжээний алдаа хэт бага эсвэл өндөр гарахаар байгаа тул хувь хэмжээг 2%-оор сонгох нь зохистой гэж үзсэн.</li> </ul>

## Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлээмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг тусдаа байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Аудитын гол асуудал	Аудитын гол асуудалд авсан хариу арга хэмжээ
<p><b>Даатгалын хураамжийн орлого хүлээн зөвшөөрөлт</b></p> <p>Компани нь даатгалын үйлчилгээг хуримтлалын бүтээгдэхүүнтэй хослуулан даатгуулагчдад хүргэдэг ба даатгалын бүтээгдэхүүний төрлөөс хамааран хураамжийн дүн, төлөгдөх хугацаа харилцан адилгүй байдаг байна.</p> <p>Хуримтлал хэлбэрийн даатгалын хураамжийн орлого нь даатгуулагчийн төлөх дүн, төлөлтийн давтамжтай уялдаатай тул мөнгөн сууриар, харин эрдэл бүхий даатгал болох амь насны даатгал, эрүүл мэндийн даатгалын хураамжийн орлогыг аккруэл сууриар хүлээн зөвшөөрч бүртгэдэг байна.</p> <p>Компанийн даатгалын бүтээгдэхүүний онцлог, хугацаанаас хамааран хураамжийн орлогыг бүртгэлийн 2 сууриар хослуулан хүлээн зөвшөөрч байгаа тул аудитын гол асуудал гэж үзлээ.</p>	<p><b>Гүйцэтгэсэн аудитын горим:</b></p> <p>Бид даатгалын хураамжийн орлогын хүлээн зөвшөөрөлт үнэн зөв хийгдсэн эсэхийг үнэлэхдээ дараах аудитын горимыг хэрэгжүүлсэн.</p> <ul style="list-style-type: none"> <li>Удирдлагын хэрэгжүүлсэн даатгалын хураамжийн орлого хүлээн зөвшөөрөх нягтлан бодох бүртгэлийн зохистой байдлыг авч үзсэн ба холбогдох СЗХ-ны журмын шаардлагад нийцсэн байгаа эсэхийг үнэлсэн.</li> <li>Даатгалын гэрээний мэдээллийг үнэн зөв бүртгэсэн эсэхийг нийт хүчинтэй гэрээнээс түүвэр бэлтгэн даатгалын программын гэрээний мэдээлэлтэй тулгасан.</li> <li>Даатгалын гэрээний бүртгэл, авлага орлого бүртгэх процесс, түүний хяналт зүй зохистой хэрэгжиж буй талаар судлан үнэлсэн.</li> <li>Даатгалын хураамжийн орлогыг аккруэл сууриар бүртгэхдээ үнэн зөв тооцоолсон эсэхийг гэрээнээс түүвэр бэлтгэн шалгасан. Мөн тайлант хугацаанд гэрээний хугацаа дууссан байгууллагуудын гэрээ дүгнэсэн актыг авч бүртгэлтэй тулгасан.</li> </ul>

## Санхүүгийн тайланын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй.

Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

### Аудитор нь залилан зэрэг хууль бус асуудлуудыг илрүүлэх чадавхийг ямар цар хүрээнд авч үзсэн талаарх тайлбар

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх үзлийг хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохиорохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хувалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохиорохуйц аудитын горим боловсруулах зорилгоор аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэслэлтэй, байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ, үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.
- Санхүүгийн тайланд дүгнэлт өгөх зорилгоор компани доторх бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээллийн талаар хангалттай зохистой нотолгоо олж авдаг. Бид компанийн аудитыг чиглүүлэх, хянах, гүйцэтгэх үүрэгтэй. Бид зөвхөн өөрсдийн аудитын дүгнэлтээ хариуцлага хүлээнэ.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий удирдлагатай харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад чухал асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээллэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцаах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг

үр дагавартай учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

### Төлбөрийн чадварын талаар

СЗХ-ны 2023 оны 559 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам"-ын 2.19-д заасны дагуу компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төлбөрийн чадварын харьцаа Хоёрдугаар түвшин болох даатгагчийн төлбөрийн чадвар хангалттай (2023 онд Нэгдүгээр түвшин буюу хангалттай) байгаа нь уг журмын шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

### Аудитын тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг "Компанийн тухай" хуулийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн туравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.



Огноо: